



"ШТН" ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.БАТТУЛГА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/276
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

"ШТН" ТӨААТҮГ-ын удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

"ШТН" ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"ШТН" ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА



**ШШГЕГ-ЫН “ШОХОЙ ТООСГО
НЭГДЭЛ” ТӨААТҮГ-ЫН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663

Аудитын менежер Н.Золзаяа

Утас: 260512

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512

“Ньюбаланс аудит” ХХК

Аудитор Д.Гэрэлчулуун

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ. /САГ-2017/7/СТА-УТҮГ/

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олонулсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2016оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн ШШГЕГ-аас гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн Сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 12 дүгээр сарын 05-наас 2017 оны 2 дугаар сарын 17-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалга гэрээний дагуу “Ньюбаланс Аудит” ХХК-ийн 2 дугаар багийн аудиторуд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 25-нд 03/116тоот албан бичгээр ирүүлсэн.

Үндэсний аудитын газар аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд ШШГЕГ-ын Шохой Тоосго Нэгдэл ТӨААТҮГ-ын төвийн удирдлагад гардуулав.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын захирагч нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

ШШГЕГ-аас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, холбогдох хууль тогтоол бусад эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20-р зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18.1-р зүйлд Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын захирал удирдана ” гэж заасан байна.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ –ын үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 27-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС-тай нийцсэн байна.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах

аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ нь “Ординат” ХХК-ийн “Unicus” нэртэй санхүүгийн програмыг бүрэн ашиглан санхүүгийн тайланг програмаас бэлтгэн гаргаж байна.

Материаллаг байдлыг тооцсон тухайд:

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2016 оны 3-р улиралын нийт зардлын 2 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 4.2 сая төгрөг гэж тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны жилийн эцсийн нийт зардлын дүнгээр түвшинг шинэчлэн тогтоож 7.0 сая төгрөг болгож тооцсон. Учир нь нийт хөрөнгө, цэвэр хөрөнгийн дүнгүүд өндөр байгаа тул нийт зардлаас тооцох нь зүйтэй гэж үзсэн.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төлөвлөгөөний орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

ШШГЕГ-ын “Шохой Тоосго Нэгдэл” ТӨААТҮГазар нь тайлант онд 485.0 сая төгрөгийн борлуулалтын орлого батлагдсанаас гүйцэтгэлээр 225.6 сая төгрөгийн борлуулалт хийж төлөвлөгөөг 53,5%-иар буюу 259.4 сая төгрөгөөр тасарсан. Борлуулалт тасарсан шалтгаан гол борлуулалт эзэлдэг шохойны борлуулалт батлагдсан төсвөөр 3.5 мянган тонн, гүйцэтгэлээр 1.1 мянган тонн борлуулалт хийгдсэн нь 2016 оны барилгын салбарын үйл ажиллагаа зогсонги байдалтай холбоотой буурсан. ШШГЕГ-т 70.0 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөг 100 хувь төвлөрүүлсэн.

Шилэн дансны мэдээлэл:

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байхад нийцүүлэн shilendans.gov.mn сайтад батлагдсан маягт хавсралтуудын дагуу төсөв, гүйцэтгэл, 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авах ажиллагаа, бусад зарлагын гүйлгээний мэдээллийг сар бүр байршуулж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 47 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 27 хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, хөрөнгө, бусад орлого, тээвэр шатахуун зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг доор тэмдэглэв. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлан дахь авлагын үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлийн журналын бичилттэй тулган шалгахад Дөл түшиг ХХК-нд өгөх 735.5 мянган төгрөгөөр авлага буруулан тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д бие даасан байх, тасралтгүй байх, жинхэнэ хэрэгжилтийн, үнэн зөв байх, хэмжигдэхүйц байх, зохицох гэсэн зарчмууд, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад дээрх алдааг танилцуулж нягтлан бодох бүртгэлийн журналын бичилтэд залруулга хийлгэв.

2. Шохойны өртөг өмнөх онд 65.0-81.0 мянган төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан бол 2016 онд дунджаар 125.6 мянган төгрөг болж 55 хувиар өссөн байна. Байгалийн хүчин зүйл, технологоос шалтгаалан бүтээгдэхүүний гарц багассан гэх тайлбарыг өгч байгаа ч үйлдвэрлэлийн шат дамжлагад гарч буй хэвийн, хэвийн бус хорогдлуудад тавигдах норм нормативыг хангаж ажиллах, бүтээгдэхүүний гарцад тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллах нь зүйтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад асуудлын бүртгэлээр танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

3. 2014 оноос ашиглаж эхэлсэн 175.0 сая төгрөгийн анхны өртөгтэй Экскеваторыг ашиглагдах жилийг 5 жилээр тогтоож жилд 35.0 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцож байгаа нь тайлант үеийн ашиг алдагдалд

материаллаг хэмжээгээр нөлөөлж байна. Тус байгууллагын НБББББ-т хүнд машин механизмын элэгдлийг тооцох аргачлалыг оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад асуудлын бүртгэлээр танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

4. Урьдчилж орсон орлогын 17.2 сая төгрөгөөр авлагын үлдэгдлийг бууруулан тайлагнасан нь ШШГЕГ-ын НБББББ-ийн 4.6.6-ийн өр төлбөр хүлээн зөвшөөрөлт гэсэн хэсэгт "Харилцагч гэрээт байгууллагууд цахилгаан, дулаан уурын төлбөр эсвэл бараа, хөрөнгө худалдан авах зорилгоор урьдчилан төлбөр гүйцэтгэж байгууллагын мөнгөн хөрөнгө нэмэгдсэн үед уг тооцоог Урьдчилж орсон орлого хэмээн төлөгдсөн дүнгээр нь хүлээн зөвшөөрч өр төлбөрөөр бүртгэнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад дээрх алдааг танилцуулж нягтлан бодох бүртгэлийн журналын бичилтэд залруулга хийлгэв.

5. "Хэрэмт цамхаг" УТҮГ-т 2016 оны 7 сарын 18-ны өдөр борлуулсан 20.1 тонн шохойг гэрээнд заасны дагуу 1 тонныг нь 115.0 мянган төгрөгөөр борлуулах байтал, 90.0 мянган төгрөгөөр тооцож 456.4 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн, мөн "Бүрд Сондуул" ХХК-д 1,070.4 мянган төгрөгийн өртөг бүхий 60.0 тонн шохойн чулууг 1 тонныг 18.0 мянган төгрөгөөр борлуулах байтал 13.2 мянган төгрөгөөр тооцож 350.4 мянган төгрөгний алдагдал хүлээсэн байна. Үүнд тус үйлдвэрийн газрын даргын тушаал гарсан боловч үнэ бууруулах болсон шалтгаан тодорхой бус, мэргэжлийн комиссын дүгнэлтгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад асуудлын бүртгэлээр танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитаар нийт 17.9 сая төгрөгийн алдааг илэрснийг залруулсан тул залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

ШШГЕГ-ын "Шохой тоосго нэгдэл" ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал байхгүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

ШШГЕГ-ын "Шохой тоосго нэгдэл" ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 57.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 17.9 сая төгрөгийн

алдааг залруулж, 39.6 сая төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд зөвлөмж өгөөгүй.

Зөрчилгүй санал дүгнэлт

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ШШГЕГ-ЫН “ШОХОЙ ТООСГО НЭГДЭЛ” ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

**Нэмэлт мэдээлэл
авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:**

Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663

Аудитын менежер
Н.Золзаяа
Утас: 260512

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512

“Ньюбаланс аудит” ХХК
Аудитор Д.Гэрэлчулуун

Тэргүүлэх ач холбогдол №1:

Асуудал 1
Бүтээгдэхүүний өртгийн талаар хуудас 3

Асуудал 2
Үндсэн хөрөнгийн элэгдлийн
талаар хуудас 4

Асуудал 3
Борлуулалтын орлогын талаар хуудас 5

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт:

Шохойны өртөг өмнөх онд 65.0-81.0 мянган төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан бол 2016 онд дундажаар 125.6 мянган төгрөг болж 55 хувиар өссөн байна. Байгалийн хүчин зүйл, технологиос шалтгаалан бүтээгдэхүүний гарц багассан гэх тайлбарыг өгч байгаа ч үйлдвэрлэлийн шат дамжлагад гарч буй хэвийн, хэвийн бус хорогдлуудад тавигдах норм нормативыг хангаж ажиллах, бүтээгдэхүүний гарцад тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллах нь зүйтэй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Үйлдвэрлэлийн шат дамжлагад гарч буй хэвийн, хэвийн бус хорогдлуудад тавигдах норм нормативыг хангаж ажиллах, бүтээгдэхүүний гарцад тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх.

Эрсдэл:

- Бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлсэн байх.

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт:

2014 оноос ашиглаж эхэлсэн 175.0 сая төгрөгийн анхны өртөгтэй Экскаваторыг ашиглагдах жилийг 5 жилээр тогтоож жилд 35.0 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцож байгаа нь тайлант үеийн ашиг алдагдалд материаллаг хэмжээгээр нөлөөлж байна. Тус байгууллагын НБББББ-т хүнд машин механизмын элэгдлийг тооцох аргачлалыг оруулаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

НБББББ-т хүнд машин механизмын элэгдлийг тооцох аргачлалыг оруулах.

Эрсдэл:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоолол үндэслэлгүй байх.

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт:

“Хэрэмт цамхаг” УТҮГ-т 2016 оны 7 сарын 18-ны өдөр борлуулсан 20.1 тонн шохойг гэрээнд заасны дагуу 1 тонныг нь 115.0 мянган төгрөгөөр борлуулах байтал, 90.0 мянган төгрөгөөр тооцож 456.4 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн, мөн “Бүрд Сондуул” ХХК-д 1,070.4 мянган төгрөгийн өртөг бүхий 60.0 тонн шохойн чулууг 1 тонныг 18.0 мянган төгрөгөөр борлуулах байтал 13.2 мянган төгрөгөөр тооцож 350.4 мянган төгрөгний алдагдал хүлээсэн байна. Үүнд тус үйлдвэрийн газрын даргын тушаал гарсан боловч үнэ бууруулах болсон шалтгаан тодорхой бус, мэргэжлийн комиссын дүгнэлтгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Мэргэжлийн комиссын дүгнэлтэд үндэслэн гэрээний үнийн дүнг бууруулах шийдвэр гарган, хэрэгжүүлж байх

Эрсдэл:

- Үндэслэлгүйгээр борлуулалтын гэрээний үнийг бууруулан тооцох.

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ШШГЕГ-ын "Шохой тоосго нэгдэл" ТӨААТҮГ

2016.01.01 - 2016.12.31

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 01-р сарын 01	2016 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,384,022.99	5,239,994.43
1.1.2	Дансны авлага	60,621,504.00	38,914,851.54
1.1.3	Ажилчдаас авах авлага		6,519,936.37
1.1.4	Бусад авлага	58,736,684.54	85,881,333.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	29,161,446.04	60,424,266.46
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		8,000,000.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	159,903,657.57	204,980,381.80
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	294,974,243.42	202,690,522.90
1.2.2	Биет бус хөрөнгө	5,223,833.30	5,238,948.67
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	35,717,616.67	28,453,016.71
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	335,915,693.39	236,382,488.28
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	495,819,350.96	441,362,870.08
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	42,775,015.66	111,172,015.66
2.1.1.2	Цалингийн өглөг	41,226.57	41,226.57
2.1.1.3	Татварын өр	558,157.04	22,242,103.29
2.1.1.4	ЭМД-ийн өглөг		
2.1.1.5	Бусад өглөг		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Системийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		

2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	25,900,769.68	25,900,769.68
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	69,275,168.95	159,356,115.20
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	69,275,168.95	159,356,115.20
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:- төрийн	463,909,966.01	463,909,966.01
2.3.2	- хувийн		
2.3.3	Халаасны хувьцаа		
2.3.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(37,365,784.00)	(181,903,211.13)
2.3.8.1	Тайлангийн үеийн	(46,678,839.62)	(145,044,304.53)
2.3.8.2	Өмнөх үеийн	9,313,055.62	(36,858,906.60)
2.3.11	Эздийн өмчийн дүн	426,544,182.01	282,006,754.88
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	495,819,350.96	441,362,870.08

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ШШГЕГ-ын "Шохой тоосго нэгдэл" ТӨААТҮГ

2016.01.01 - 2016.12.31

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 01-р сарын 01	2016 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	366,974,409.23	225,545,118.23
2	Борлуулалтын өртөг	265,917,707.78	214,235,129.50
3	Нийт ашиг (алдагдал)	101,056,701.45	11,309,988.73
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	205,898.16	55,351.65
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	177,636,448.28	122,808,916.13
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(48,422,969.25)	(15,277.73)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	78,132,614.10	(33,579,915.89)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(46,664,203.82)	(145,038,769.37)
19	Орлогын татварын зардал	14,635.80	5,535.16
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(46,678,839.62)	(145,044,304.53)
21	ашиг (алдагдал)	-	
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(46,678,839.62)	(145,044,304.53)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(46,678,839.62)	(145,044,304.53)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ШШГЕГ-ын "Шохой тоосго нэгдэл" ТӨААТҮГ

2016.01.01 - 2016.12.31

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	137,013,867.72		21,272,076.02			305,624,022.27	(37,365,784.00)	426,544,182.01
2	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							506,877.40	506,877.40
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(145,044,304.53)	(145,044,304.53)
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт								-
7	Зарласан ногдол ашиг								-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
9	2016 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	137,013,867.72	-	21,272,076.02	-	-	305,624,022.27	(181,903,211.13)	282,006,754.88

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ШШГЕГ-ын "Шохой тоосго нэгдэл" ТӨААТҮГ

2016.01.01 - 2016.12.31

(төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Эцсийн үлдэгдэл
ҮНДСЭН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	349,684,644.16	183,771,144.00
Бараа борлуулсан,үйлчилгээ үзүүлсний орлого	337,407,246.00	183,211,144.00
Эрхийн шимтгэл,хураамж,төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Татаас санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	12,277,398.16	560,000.00
Мөнгөн зарлагын дүн (-)	360,814,661.11	203,970,524.21
Ажиллагчдад төлсөн	92,706,431.69	105,293,829.34
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,233,633.58	2,636,272.82
Бараа материал худалдан авахад төлсөн	21,448,317.50	41,712,163.04
Ашиглалтын зардалд төлсөн	93,209,825.00	1,949,163.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	39,026,334.54	25,524,880.00
Татварын байгууллагад төлсөн	59,161,047.49	10,430,870.83
Даатгалын төлбөрт төлсөн	162,400.00	273,258.00
Бусад мөнгөн зарлага	48,866,671.31	16,150,087.18
Хүүний төлбөрт төлсөн		
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(11,130,016.95)	(20,199,380.21)
Мөнгөн орлогын дүн (+)		42,055,351.65
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		42,000,000.00
Хүлээн авсан хүүний орлого		55,351.65
Хүлээн авсан ногдол ашиг		
Улсын төсвийн хөрөнгө оруулалт		
Мөнгөн зарлагын дүн (-)	418,000.00	18,000,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		18,000,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	418,000.00	
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР	(418,000.00)	24,055,351.65
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал		
Мөнгөн орлогын дүн (+)		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Мөнгөн зарлагын дүн (-)	-	10,000,000.00
Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Бусад		10,000,000.00
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДЭН	-	(10,000,000.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(11,548,016.95)	(6,144,028.56)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,932,039.94	11,384,022.99
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,384,022.99	5,239,994.43